

**Монгол намтар зохиолд бичиг тэмдэглэлийн эх хөрөнгийг
ашигласан нь**

Замбалгаравын ПҮРЭВСҮРЭН

Монгол Улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Утга зохиол судлалын салбарын ЭШДаА, Доктор (Ph.D)

Хураангуй: Энэхүү өгүүлэлд намтар зохиолын хэдэн зуун жилийн хөгжлийн явцад түүнтэй холбоотойгоор үүсэн бий болсон “Намтрын хөрөнгө” буюу “Намтрын эх хөрөнгө” хэмээх ухагдахуун, түүний нэгээхэн хэсэг болох “Бичиг тэмдэглэлийн эх хөрөнгө”-ийн талаар тусгайлан авч үзэв. Улмаар “Бичиг тэмдэглэлийн эх хөрөнгө”-д хамаарах гол гол эх хэрэглэгдэхүүн, тэдгээрийн ерөнхий онцлог, агуулга хэлбэр, үр нөлөө, үүрэг зориулалтын тухай тоймлон өгүүлэв. Үүний үр дүнд “Бичиг тэмдэглэлийн эх хөрөнгө” нь түүхэн үнэ цэн, ач холбогдлын хувьд аливаа намтрыг эмхэтгэн найруулах, туурвин бичих хамгийн чухал эх сурвалж болдог төдийгүй намтар зохиолыг түүхэн уран зохиолд хамруулан авч үзэх гол үндэслэл болдгийг тодорхойлов.

Түлхүүр үг: Намтар зохиол Эх хөрөнгө Бичиг тэмдэглэлийн эх хөрөнгө

Намтар зохиолыг найруулан бичихдээ туурвигч олон зүйл бэлэн материал, аман мэдээ, эх хэрэглэгдэхүүнийг тогтсон уламжлалын дагуу тодорхой эрэмбэ дараатайгаар ашиглах нь бий. Ийн ашиглахдаа тэд юун түрүүнд он цаг, газар орон, үйл явдлын дэс дараа, уялдаа холбоог анхааран харгалзаж түүнийгээ тодорхой эх сурвалжаас эш татан баримт нотолгоотойгоор оруулдаг байжээ. Энэ нь түүхэн шинжтэй намтрууд дээр илүү тод анзаарагдана. Ер нь дийлэнх намтрыг ямар эх хэрэглэгдэхүүн ашиглаж хэрхэн бичсэн тухайгаа туурвигч олонхдоо заавал дурдсан байдаг нь уг бүтээлийн түүхэн ач холбогдлыг бататган тодруулах, түүнийг үнэ цэнтэй эх сурвалжийн хувиар судалгаанд ашиглах бололцоотойг харуулдаг. Бас намтар зохиолыг түүхэн уран зохиолд хамруулан авч үзэх гол үндэслэл болдог.

Намтар зохиолын хэдэн зуун жилийн хөгжлийн явцад түүний дээр дурдсан өвөрмөц онцлог, зүй тогтолтой холбоотойгоор олон ойлголт бий болсны нэг нь “Намтрын хөрөнгө”, “Намтрын эх хөрөнгө” хэмээх ухагдахуун юм. Ерөнхийдөө

* © 3.Пүрэвсүрэн 2024
Email: z.purevsuren88@gmail.com

бол аль нэг намтрыг эмхэтгэн найруулах, туурвин бичихэд ашигласан эх хэрэглэгдэхүүнийг “Намтрын хөрөнгө” буюу “Намтрын эх хөрөнгө” хэмээн тодорхойлж буй юм. Энэхүү ухагдахууныг дотор нь “Аман уламжлалын эх хөрөнгө”, “Бичиг тэмдэглэлийн эх хөрөнгө” хэмээн ангилж болох бөгөөд тэдгээр нь тухайн намтрыг туурвих чухал эх сурвалж болдгийн хувьд ихээхэн ач холбогдолтой. Эдгээр нь бүгд өөрийн гэсэн өвөрмөц онцлог, үүрэг нөлөөтэй тул алийг нь ч орхигдуулалгүй судлан шинжлэх шаардлагатай юм. Гэхдээ энд тэр бүгдийг биш зөвхөн бичиг тэмдэглэлийн эх хөрөнгийн талаар авч үзье. Учир нь энэ ангилалд багтах эх хөрөнгө нь харьцангуй өргөн хүрээг хамардаг, түүхэн баримтын хувьд үнэнд илүү ойр, үнэ цэнтэй байдаг зэрэг нь түүнийг тусгайлан авч үзэх нөхцөлийг бүрдүүлдэг юм.

Бичиг тэмдэглэлийн эх хөрөнгө гэдэгт бурхны шашны дэлгэрэлтийн тухай тусгайлан өгүүлсэн бүтээлүүд буюу шашны түүхийн зохиолууд, түүхэн сурвалж бичиг, шашин номын мэргэдийн сүмбүм, хутагт хувилгаадын намтар цадиг, сонссон номын тэмдэглэл, тэр цагийн хууль цааз, зарлиг сэлтийн эмхэтгэл, захиа бичиг, сүм хийдийн данс эвхмэл, аян замын тэмдэглэл, тухайн намтрын гол дүрийн гэгээнтний айлдвар зарлиг болон зохиол бүтээл, Энэтхэг, Төвөд, Монголын бурхны шашны зүтгэлтэн, ном бичгийн мэргэдийн бүтээл туурвил, айлдвар сургаал зэргийг хамруулан ойлгож байна. Эдгээрийг түүхэн шинжтэй дийлэнх намтарт ямар нэг хэмжээгээр заавал ашигласан байдаг нь тохиолдлын хэрэг биш. Учир нь намтар зохиол бол түүхэн уран зохиолын айд хамаарах, уран зохиолын өвөрмөц онцлог бүхий бие даасан бүтээл болохын хувьд бодит үнэнийг тодорхой хэмжээгээр тусгадаг онцлогтой. Тийм ч учраас урьдын мэргэд, бичиг номын хүмүүс аль нэг мадагтай зүйлийг тодруулах, эргэлзээтэй асуудлыг тайлахдаа хутагт хувилгаадын намтрыг түүхэн эх сурвалжийн хувиар лавлалт болгон ашигладаг байжээ. Аливаа намтар, тэр дундаа түүхэн намтрыг туурвигч нь аль болох үнэнийг өгүүлэхийг үүрэг хэмээн үзэж үндэслэл нотолгоотой хэрэглэгдэхүүнийг эх хөрөнгө болгон ашигладаг, түүнийхээ уг сурвалжийг дурддаг, хэрхэн яаж ашигласнаа тайлбарладаг байсан нь ч үүнтэй холбоотой. Үүний нэгэн адилаар туурвигч зарим хэрэг явдлын талаар тодруулан дэлгэрүүлж чадаагүй буюу түүнийг батлах баримт сэлт олдоогүй тохиолдолд тэр тухайгаа ч бас тэмдэглэдэг уламжлал нэгэнт хэвшин тогтжээ.

Үүний тодорхой жишээ бол Зая бандид Лувсанпрэнлэйн туурвисан Өндөр гэгээний намтрын дотор байгаа “...Гүндэн хэмээх Төмөр Хулгана (1660) жилийн хавар би Үй Занд явах тухайгаа айлтгахад машид баясан соёрхов. Гэгээнтэн өөрийн мутрын нэг эрх, нэг том хүлэг морийн хишиг хайрлав. Төмөр Хулгана (1660) жилээс Шороо Хонин жил (1679) хүртэл би Дашилхүнбо тэргүүтэн Үй Зан мужид суусан учир энэ хоорондын (Богдын) намтар үйл явдал нь тодорхой бус болой” (Лувсанпрэнлэй, 1995:11) гэсэн тэмдэглэл болно. Энэ бол туурвигч нь уг намтарт өөрийн биеэр үзэж харсан, гарцаагүй мэдэж буй, баримт нотолгоотой хэрэг явдлын талаар бичихийг чухалчилж байсны илрэл мөн. Түүнчлэн уг

намтарт ямар нэг бодитой баримт нотолгоо олдоогүйгээс зарим зүйлийн талаар тодорхой бичиж чадаагүйгээ туурвигч өөр газруудад бас тэмдэглэсэн байдаг нь ч бидний дээр дурдсан саналыг баталж буй хэрэг юм. Ийм баримт бусад монгол намтар зохиолын дотор ч цөөнгүй тохиолдоно. Үүний жишээнд Нэйж тойн хутагтын хоёрдугаар дүрийн намтар “Сүсгийн зул”-д туурвигч гол дүрийн гэгээнтний эш хүртсэн, ном сонссон талаар өгүүлэхдээ зарим нэг авшиг, даган соёрхол, эш хөтөлбөр сонссон ном зэргийн тэмдэглэлийг олж чадаагүйн улмаас бүгдийг нь бүрэн гүйцэд бичээгүй, ашигласан тэмдэглэл нь хэдий хагас дутуу боловч тэдгээрийг хэн хэнээс сонсож мэдсэнээ тодорхой өгүүлсэн байдаг (Сүсгийн зул, 2010:280-281)-ийг дурдаж болно. Энэ бол туурвин бичигч нь намтар зохиолд аль болох бодит үнэнийг өгүүлэхийг эрхэмлэдэг байсны бас нэгэн баталгаа мөн.

Эдгээрээс гадна зургадугаар далай ламын намтар “Хамгийг айлдагч Агваанчойдогжамц цог сайтын намтар хэтэрхий гайхамшигт сайн зохионгуйн яруу аяст тэнгэрийн ятгын эгшиг хэмээгдэх оршвой”-д бидний дээр өгүүлснийг батлах өөр нэгэн баримт байна. Уг намтрын эхэнд туурвигч Агваанлхүндүвдаржай бээр “...Энэ цагт зарим шавь нар өөрийн ламдаа бусдыг сүсэглүүлэхийн тулд эрдмүүдийг нь өсгөн зохиож олонтоо өгүүлэх ба заримууд нь ламынхаа намтрыг өгүүлэхийг өөрийнхөө эрдмийг гаргахын арга болгох буюу бусдыг дооршоон гутаах тэргүүтнийг үйлдмөй. Би бээр бодитойг бүтээх боловч номлохуйд ухаан мөхөс бөгөөд үйлийн үр гэгч маш нарийн тул өөрийн биедээ олон төрөлд хорлол амсуулах олиу солиу үгс тэр мэтийг номлоод өчүүхэн ч тус болж чадахгүйн дээр номын нүдтэн бүгдэд сонжигдохуйд хүрэх ба зөвхөн миний бие төдийгөөр үл баран буй бүхий байдлыг мэдэгч эрхэм доод гэсэнгүй эдүгээ байх бүхэн ч сонжигдохын орон болохоос эмээн үл бичих бөлгөө” (Агваанлхүндүвдаржай, 1999:12) хэмээсэн байдаг. Эндээс бид тухайн үеийн шашин номын мэргэд намтар зохиолд бодит үнэнээс хол, худал хуурмаг зүйл бичихийг нүгэл хэмээн үзэж ихэд цээрлэн болгоомжилдог байсныг ажиглаж болно. Мөн тэр цагийн намтрыг туурвин бичдэг дэг ёс, баримталдаг зарчим, дүрэм журмын талаар ч ойлгох боломжтой. Учир нь тухайн үеийн ном бичгийн хүмүүс намтрыг энэ болон хойтын буяны тулд бичсэн болохоо тэмдэглэсэн байдаг бөгөөд худал хуурмагийг зохион бичиж, бусдыг гүтгэн доромжилбол харин буян биш нүгэл болно хэмээн үздэг байсан ажээ. Энэхүү үзэл ойлголт нь нэг талаар аливаа намтарт төрийн ихэс дээдэс, эгэл жирийн хар хүний явдлыг биш, нэг насаараа буяны үйлд шамдсан хутагт хувилгаад, шашин номын мэргэдийн үйл зохионгуйг дүрслэн харуулдагтай холбоотой. Нөгөө талаар тухайн намтарт гол дүрийн хувиар дүрслэгдэж буй хутагт хувилгаад эсвэл түүний шавь нар, үйл хэргийг нь үргэлжлүүлэн залгамжлагчид буюу хойчийн сүсэгтэн, шашин номын хүмүүс ихэнх намтрыг туурвин бичдэг байсантай ч хамаатай. Үүнээс гадна энд бас тухайн үеийн зарим намтар, түүнийг туурвин бичигчдийн алдаа дутагдал, гэм бурууг гярхай ажиглаж шүүмжлэлтэй хандаж байсан зохиогчийн бодол

сэтгэлгээ ч тод тусжээ.

Энэ мэт жишээ Цахар гэвш Лувсанчүлтэмийн намтар, Дамцигдоржийн гэгээнтний намтар зэрэг бусад монгол намтарт ч бас бий. Тухайлбал Цахар гэвш Лувсанчүлтэмийн намтарт “...Бас үүний урьд хожид нугуудад ч аврал Богд гэгээнтнээ амгаланг айлтгах бичиг хийгээд аль хэртэй нэжгээд өргөлгийг тасралгүйеэ өргөсөөр байсан бөгөөд түүгээр үл баран хожим үед Бэйжинд заларч байх үе тэргүүтнээ ямар мэт зохистой өргөлгийг үргэлж тасралгүйеэ өргөсөөр байдгийг нь бид дэргэд агчин бүгдээр үзсээр байсан боловч тэдгээр тухай тухайд Мартахын тэмдэг тэргүүтнийг үйлдсэнгүй тул энд нарийвчлан бичиж эс чадав” (Лувсансамдүвням, 2010:152) хэмээсэн байдаг нь үүнийг батлах баримт болно. Туурвигч энд Цахар гэвш Лувсанчүлтэм Ажаа гэгээнтний хувилгаан гэгээнтэн хоёрын хоорондын харилцааны талаар өгүүлсэн бөгөөд зарим нэг хэрэг явдлын тухай мэдэж байгаа хэдий ч түүнийг нь батлах баримт олдоогүй тул нарийн тодорхой бичиж чадаагүйгээ хэлжээ. Тэгвэл гэвш Галсанбалжир, хамба равжамба Галсан-Иш нарын туурвисан Дамцигдоржийн намтарт түүний сонссон номын талаар ярихдаа “...Бас бус, Ганжуураас боть дүнжүүгийн аймгийн уншлагын лүн даяар хийгээд жисүрийн ван, жэнан, тид, тэргүүтэн зэргэмжийг өршөөснийг бичиж гүйцэшгүй байгаа мэт байх боловч баримт олдоогүйг энд бичиж чадсангүй болой” (Галсанбалжир., Галсан-Иш, 2011:137) хэмээн өгүүлсэн байдаг нь мөн л намтар зохиолд баримт нотолгоотой зүйлийн талаар бичдэг байсны бас нэгэн баталгаа мөн.

Энэ мэтээр зарим хэрэг явдлын тухай тодорхой мэдэхгүй буюу баттай эх хөрөнгө байхгүйгээс тэр талаар нарийвчлан дэлгэрүүлж оруулаагүй тохиолдол өөрийн бичсэн намтрын дотор ч бас тааралдана. Жишээ нь, цорж Агваанбалдан бээр өөрийн намтартаа номлосон ном, бусдад өгсөн лүн жинангийнхаа талаар дурдахдаа зарим санахгүй байгаа зүйлээ бичээгүй болохоо хэд хэдэн газар тэмдэглэсэн байдаг. Жишээ нь тэрхүү намтарт “...Тэр жил дуртгаагчны хүслийн дагуу Дэмбэрэл додвагийн тайлбар зэрэг зарим номуудыг зохиож номонд дурлагч, чухалчлагч нарт Тидчэнши, Егүүтгэлийн хөтөлбөр зэрэг лүн хөтөлбөрүүдийг өргөсөн байсан боловч тэмдэглээгүй тул нарийвчлан эс бичив ээ” (Агваанбалдан, 2007:24-25) хэмээсэн нь бий. Эдгээр жишээ нь бүгд намтар зохиолыг баримт нотолгоотой эх хөрөнгө дээр тулгуурлан бичдэг байсны баталгаа юм. Бас туурвигч нь маш олон зүйл эх хөрөнгийг ашигласны үр дүнд намтрыг найруулан бичдэг байсны илрэл мөн.

Үүнээс гадна зарим намтрын туурвигч нь тэр олон эх хэрэглэгдэхүүнийг хооронд нь харьцуулж ялгаа зөрөөг нь тодорхойлж, мадагтай заримыг нь засан залруулж, өөрийн мэдэхгүй, шийдвэрлэж чадахгүй хэсгийг тэр чигээр нь тэмдэглэн үлдээгээд тэдгээрийг шүүн тунгааж, судлан нягталж үнэн зөвийг тогтоохыг хожмын хүмүүст даатган орхисон тохиолдол ч цөөнгүй. Тухайлбал, Зая бандид Лувсанпрэнлэйн туурвисан Өндөр гэгээний намтарт халхчууд манжийг түшсэн цаг хугацааны талаар “...Халхчууд нь Манж эзэн Энх-Амгалан

хааны гучдугаар он (Цагаан хонин жил) манжийг түшжээ. Үүнийг Цагаан Могой жил гэж Балманцан гэгээн айлдсан байдаг. Бас Шар Могой жил ч гэж бичиж тэмдэглэсэн үзэгддэг” (Дагважанцан, 1995:23) хэмээсэн байдаг нь туурвин бичигч тухайн үйл явдалтай холбоотой адил бус олон тэмдэглэлийг харьцуулсны үр дүнд тэр талаар бичсэнийг илтгэдэг юм.

Ерөнхийдөө бол намтар зохиолд ашиглагдсан эх хөрөнгийг ажиглахад тоо хэмжээ, хэрэглэгдсэн давтамжийн хувьд харилцан адилгүй байдаг. Үүнд тухайн эх хөрөнгийн уран зохиолын болон түүхэн шинжийн харьцаа, уг намтрын бичигдсэн цаг үеийн нөхцөл байдал, агуулга, үзэл санаа, тархац, олдоц зэрэг олон хүчин зүйл шууд ба дам байдлаар нөлөөлдөг. Тухайлбал, сонссон номын тэмдэглэл, сүм хийдийн данс эвхмэл, хууль цаазын бичиг зэрэг эх хөрөнгө нь данслан бүртгэсэн, дугаарлан тоочсон албан буюу хувийн шинжтэй тэмдэглэл төдий байдаг бол зарим намтрын эхлэл хэсэгт дагалт маягаар ордог хутагт хувилгаадын эрт урьдын олон дүрүүдийн үйл зохионгуйг дүрсэлсэн цадиг тууж тэргүүтэн, түүнчлэн шашин номын мэргэдийн сүмбүм, зохиол бүтээл, захидал харилцааны бичиг зэрэг нь уран зохиолын онцлог шинжээрээ гойд уянгалаг яруу байх жишээтэй. Чухамдаа энэхүү өвөрмөц онцлог нь тэдгээрийг намтар зохиолд хөрөнгө болгон түлхүү ашиглах үндэслэл болдог байх талтай. Учир нь тухайн намтарт уран яруу шүлэг дуулал, домог хуучийг хэдий чинээ их оруулна, уншиж сонирхох урам зориг төдий чинээ их байх нь мэдээж. Гэхдээ энд түүхэн бодит үнэнийг сонирхон уншигчийн сэтгэлийг татгал уран яруугаар, уйдаан залхаахгүйгээр илэрхийлж чадна гэдэг бол туурвин бичигчээс ихээхэн ур чадвар, хүч хөдөлмөр шаардсан ажил болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Бичиг тэмдэглэлийн эх хөрөнгийг ерөнхийд нь ажиглавал гэгээд хувилгаад, шашин номын мэргэдийн бүтээл туурвил, сүмбүм нь голлох байр эзэлдэг. Тэр дундаа тухайн намтарт гол дүрийн хувиар дүрслэгдэж байгаа хутагт хувилгаадын өөрийнх нь сүмбүм маш үнэ цэнтэй чухал эх хөрөнгө болох нь бий. Тухайлбал, цахар гэвш Лувсанчүлтэм нь Богд Зонхавын намтрыг туурвихдаа түүний сүмбүмээс олонтоо эш татан ашиглаж, зохиол бүтээлүүдээс нь намтарт нь шууд татан оруулсан байдаг. Үүний нэгэн адилаар Цахар гэвшийн шавь Лувсансамдүвням ч гэсэн багшийнхаа намтрыг бичихдээ сүмбүмийг нь бас ашигласан байдаг. Цахар гэвшийг Юн хэ гүнд өөд болон сууж байх цагт Ажаа гэгээнтэн түүнд дээдийн номын гүн оньсноос туурвисан зарлигийн зүйлийг өдөр бүр тасрал үгүйеэ айлтгадаг байсан бөгөөд Лувсанчүлтэм тэдгээрийг мартахгүйн тулд зарим нэгийг нь тэмдэглэн авсан нь өөрийнх нь сүмбүм дотор орсон байдаг ажээ. Хожим түүний шавь Лувсансамдүвням багшийнхаа намтрыг туурвин бичихдээ тэрхүү айлдвар зарлигийг сүмбүмээс нь авч оруулсан байдаг (Лувсансамдүвням, 2010:57-59) бөгөөд энэ нь намтар зохиолд гол дүрийн гэгээнтний өөрийнх нь зохиол бүтээл буюу сүмбүмийг нь ашигладаг байсны тодорхой жишээ болно. Энэ мэтээр гол дүрийн хутагт хувилгаадын өөрийнх нь зохиолыг сүмбүм болон бусад бичиг тэмдэглэл зэргээс намтарт нь шууд

татан оруулсан тохиолдол монгол намтар зохиолын дотор нэлээд түгээмэл. Дээр дурдсан хоёр жишээ бол үүний тодорхой илрэл мөн. Ийм уламжлал бүр хорьдугаар зуунд бичигдсэн намтрууд дээр ч тодорхой харагддаг. Тухайлбал, ХХ зууны эхэн үеийн шашны сонгодог боловсролтон, олноо Шар цорж хэмээн алдаршсан Дагважанцан бээр Өндөр гэгээний намтрыг бичихдээ Өөлд Халх хоёрын хямрал мөргөлдөөн, өс хонзонг амарлиулан намжаахын төлөөнөө Гэгээнтний зохиосон “Жанлавцогзол” хэмээх зохиолыг ашиглаж хэсэглэн оруулсан нь буй (Дагважанцан, 1995:26). Эдгээр жишээ бол намтар зохиолын хэдэн зуун жилийн түүхэн явцад гэгээд хувилгаадын сүмбүм болон зохиол бүтээлийг намтрын хөрөнгө болгон ашигладаг тогтсон уламжлал бий болсны баталгаа бөгөөд тэр нь нэлээд хожуу үед бичигдсэн намтрууд дээр ч илэрч байсны баримт юм.

Үүнээс гадна монгол намтар зохиолд хаад ноёд буюу төрийн ихэс дээдэс, хутагт хувилгаад, шашин номын мэргэд, багш шавь, номын ханьтнуудын харилцан бие биедээ илгээсэн захиа бичгийг нэлээд оруулсан байдаг. Мөн алс газар шашин номын үйлд шамдсан үр хүүхдэдээ эцэг эхээс нь эсвэл харь хол хүний нутгаас элгэн садан хайртай дотны хүмүүстээ илгээсэн хүүгийн захидлыг эх хөрөнгө болгон ашигласан жишээ бас цөөнгүй. Эдгээрээс тухайн захианд дурдагдсан, захиаг бичиж илгээсэн, хүлээн авсан зэрэг уг захиатай холбоотой хүмүүс болон тэр цагийн улс төр, эдийн засаг, нийгэм цаг үеийн байдлыг мэдэх боломжтой. Ийм учраас намтар зохиолд ашиглагдсан захидлууд нь намтрын бас нэгэн чухал эх хөрөнгө гарцаагүй мөн. Намтар зохиол дахь захиа бичгийн эх хөрөнгийн жишээнд Цахар гэвш Лувсанцүлтимийн туурвисан Богд Зонхавын намтарт Богдын Эрдэнэ цогцолсны ноён бээр заллага айлтгасны хариуд барьсан бичиг (Лувсанцүлтим, 2004:108-109), Хансүр цорж Агваанлуvsсандондовын туурвисан Өндөр гэгээний намтарт Гэгээнтнийг арван настай байх үед тавдугаар Далай ламаас илгээсэн захидал (Агваанлуvsсандондов, 2014:25-26) зэрэг олон жишээг дурдаж болно. Ихэнх намтрууд дахь захидлуудыг гол төлөв уран яруугаар шүлэглэн бичсэн байдаг нь намтар зохиол, тэр дундаа түүний дотор багтан уламжлагдаж ирсэн захиа бичгийн уран зохиолын онцлогийг илтгэн харуулдаг юм.

Намтар зохиолд захиа бичгийг дээр дурдсанчлан эх хөрөнгө болгон ашигласан баримт нэлээд түгээмэл тохиолдоно. Үүний жишээнд анги Шагдар ламын намтрыг бичихэд Цэдэв хэмээгчийн захиаг эх хөрөнгө болгон ашигласныг дурдаж болно. Туурвин бичигч бээр тэнд өөрийн багш анги Шагдар ламын эхээс мэндэлсэн ёс, номын аймагт яаж орсон ёс тэргүүтэн бага залуу цагийнх нь гайхамшигт явдал тэргүүтнийг бичиж тэмдэглэсэн баримт олдоогүй, залуу бага цагт нь дэргэд нь шадар бараа болж зохиол явдал бүгдийг нь гүйцэд сайн мэдэж ярих хүн одоо үгүй ч хүү түүний нагац Цэдэв хэмээгч нь өөрийн удам угсаа, орон нутгийн хүмүүсийн ам дамжсан элдэв яриа ойр чухал хэрэгтэй заримыг хураангуйлж захиа ирүүлсэн дээр тулгуурлан бичсэн болохоо тэмдэглэсэн

байдаг (Лхамаажав.Ш, 1995:18-19) нь үүний тодорхой баримт мөн. Ер нь намтар зохиол дахь захиа бичгүүдийн хэлбэр бүтэц, агуулгын ерөнхий онцлогийг ажиглахад захидал хүлээн авагчийн амар мэндийг нь айлтган эрсэн, захидал бичих болсон учир байдлаа илтгэсэн, гол хэрэг явдлаа учирлан тайлбарласан, зарим тохиолдолд хариу захидал ирүүлэхийг хүсэн даатгасан, эргэн уулзахын ерөөл дэвшүүлсэн, тухайн захидлыг хэдийд, хаана, хэн, хэрхэн бичсэн талаар тоочсон маягтай байдаг. Бичлэгийн хувьд тэдгээрийг намтар зохиолын нэгэн адил шүлэглэсэн, үргэлжилсэн, шүлэг үргэлжилснийг хослуулан бичсэн байдаг.

Монгол намтар зохиолд дээр дурдсанчлан хутагт хувилгаад, шашин номын мэргэдийн сүмбүм, захиа бичгийг эх хөрөнгө болгохоос гадна дээдийн ном дэлгэрсэн ёс буюу бурхны шашны үүсэл, хөгжил, тархалтын тухай өгүүлсэн түүхэн сурвалжийг бас нэлээд ашигладаг. Тухайлбал, ёнзон Лувсангэлэгданзаны бичсэн “Дарба бандидын цадиг «Эрдэнийн эрих»” хэмээхэд түүнийг эрт урьдын төрөлдөө их бандид Ганбэл хэмээх болж явсан талаар өгүүлдэг. Туурвин бичигч бээр уг намтарт Ганбэлын талаар өгүүлэхдээ Даранатын “Энэтхэгийн шашны түүх” ба Сүмбийн “Шашны түүх” тэргүүтнийг ашигласнаа дурдсан нь бий (Лувсангэлэгданзан, 2014:32). Энэ бол намтар зохиолыг бичихэд бурхны шашны дэлгэрэлтийн түүхийг эх хөрөнгө болгон ашигладаг байсныг батлах баримт болно. Үүнээс гадна дээрх намтарт Дарба бандидын эрт урьдын олон төрөл, түрүү дүрүүдийнх нь талаар ярихдаа ямар ямар эх сурвалжийг хэрхэн ашигласнаа туурвигч тодорхойлон заасан газар нэлээд бий. Тухайлбал уг намтрыг туурвин бичигч бээр арван нэгдүгээр дүр Салхангүжэ ринбүчи цорж Агванчойжижалцаны талаар ярихдаа ямар материал ашигласан талаараа “...Энэ хоёр их ширээтийн намтрыг Харнаг хэлмэрчийн «Гандангийн номын гарлага» хийгээд Дэсридийн «Гандангийн номын гарлага» хоёроос номлосныг уг болгож бусдаас өчүүхэн нэмэрлэн зохиосон бөгөөд үүний урьдах таван дүрийн намтраас ихийн «Гадамба номын гарлага»-аас номлосныг уг болгож Дэсридийн номын гарлага «Шар биндэрья» ба Ёнзин ринбүчийн «Мөрийн зэргийн дамжсан ламын намтар» тэргүүтэн хэмжээ төгссөн олон мэргэдийн зарлигаар ч өнцгийг чимж бичсэн болой” (Лувсангэлэгданзан, 2014:49) хэмээсэн нь бий.

Энэ ташрамд бас нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд монгол намтар зохиолд бичгийн эх хөрөнгийг дээр өгүүлсэнчлэн өргөн дэлгэр хамруулахаас гадна аман уламжлалын эх хөрөнгийг ч бас багагүй ашигласан харагддаг. Зарим тохиолдолд тэдгээрийг хамтатган оруулсан нь ч цөөнгүй. Тухайлбал, Агваанлуvsандондов бээр Өндөр гэгээний намтарт Дархан чин ван Дондовдоржийн мэндэлсэн талаар ярихдаа аман уламжлалын болон бичиг тэмдэглэлийн эх хөрөнгийн аль алийг нь ашигласан байдаг (Агваанлуvsандондов, 2014:31-32). Хэдийгээр тэнд итгэн үнэмшихэд бэрхтэй, хийсвэр, домгийн шинжтэй өгүүлэмж харагддаг боловч намтрыг туурвигч нь ямар эх хэрэглэгдэхүүнийг хэрхэн ашигласнаа тодорхой дурддаг, зарим тохиолдолд тэдгээрт аман уламжлалын болон бичиг тэмдэглэлийн эх хөрөнгийг нэгэн дор хамтатган хэрэглэдэг байсныг илтгэх баримт болно. Ийм

жишээ зургадугаар далай ламын намтрын дотор бас бий. Туурви́гч уг намтрыг бичихдээ ямар эх хөрөнгө ашигласан талаараа “...Эдүгээ үйлийн үрийг гэрч болгохын үүднээс маш ариун сүсгээр нөхцөл барилдуулан, төгс цогт лам дээдийн гэгээний намтрыг урьд айлдсанаас эвхмэл цаасанд тэмдэглэж бичсэн ба өөрийн үзэж мэдсэн хийгээд бас гэгээний амнаас сонссон сэтгэлдээ цээжилснүүдээ нэгэн чигт эмхэтгэж бичихээр илт зүглэсүгэй” (Агваанлхүндүвдаржай, 1999:16) хэмээсэн байдаг.

Монгол намтар зохиолын нэлээд түрүү үеийн дурсгал болох Нэйж тойны намтар зэрэгт бас бидний энд ярьж буй аман уламжлалын болон бичиг тэмдэглэлийн эх хөрөнгийг хамтатган ашигласан байдаг. Тухайлбал Нэйж тойны намтрын төгсгөлд зохиогч уг бүтээлийг туурвихдаа ямар эх хөрөнгө ашигласан талаараа тодорхой тэмдэглэсэн нь бий (Билгийн далай, 2010:89). Дээрх намтрын дараахан зохиогдсон Нэйж тойн хутагтын хоёрдугаар дүрийн намтар “Сүсгийн зул”-д бас тодорхой бичиг тэмдэглэл ашигласан жишээ тааралддаг. Энд өгүүлсэн жишээ баримтууд бол монгол намтар зохиолд аман уламжлалын хөрөнгийг дангаар нь хэрэглэхээс гадна бичиг тэмдэглэлийн эх хөрөнгөтэй хамтатган ашигладаг байсныг харуулж байна. Мөн аман уламжлалын хөрөнгө нь зарим тохиолдолд бичиг тэмдэглэлийн эх хөрөнгөд дурдагдаагүй мэдээ баримтыг агуулдаг, намтарт яригдаж буй тухайн дүрийн эцэг эх, авга нагац, өвөг эмэг зэрэг ойр дотны ах дүү буюу хамаатан садан эсвэл багш шавь зэрэг бичиг номын барилдлагатай түүхэн хүмүүсийн амнаас гарсан үг, болж өнгөрсөн бодит үйл явдлыг батлах дурсамж маягтай байдгаараа ихээхэн ач холбогдолтой юм.

Төгсгөлд нь дээр өгүүлснийг нэгтгэн хураангуйлбал намтар зохиолын эх хөрөнгөтэй холбоотой хэдэн чухал дүгнэлтийг хийж болно.

Нэгд, туурвин бичигч нь намтрын гол дүрийн гэгээнтний үйл амьдралтай холбоотой мэдээ баримтыг өөрийнх нь намтарт татан оруулахдаа тухайн хэрэг явдлын болж өнгөрсөн газар орон, цаг хугацааг чухалчлан анхаарч, олон талаас нь нягтлан хянадаг байсныг ажиглаж болно. Мөн маш олон зүйл эх хэрэглэгдэхүүнийг эмхэтгэн боловсруулах, эвлүүлэн найруулах нөр их ажлын суурин дээр сая тухайн намтрыг бичдэг байсныг анзаарч болно. Учир нь аль ч намтарт хөрөнгө болгон ашиглаж байгаа тэр олон эх хэрэглэгдэхүүнийг шүүн тунгааж тохиромжтой газар бүхэнд нь тодорхой дэс дарааллыг баримтлан зүй зохистойгоор оруулж тэдгээрийг хооронд нь холбон найруулж нэг томоохон бүтээлийг туурвина гэдэг бол бас багагүй ур чадвар, хүч хөдөлмөр шаардсан ажил болох нь илэрхий.

Хоёрт, бичиг тэмдэглэлийн эх хөрөнгө нь хэдийгээр тоо хэмжээний хувьд харьцангуй олон, аман уламжлалын эх хөрөнгийг бодвол нэлээд тогтвортой, харьцангуй өргөн хүрээг хамардаг боловч уран зохиолын онцлог талаасаа төдий л гоц гойд биш байна. Жишээ нь сонссон номын тэмдэглэл, сүм хийдийн данс эвхмэл, дүрэм журам, хууль цаазын бичиг, зарлиг лүндэн зэргийн тэмдэглэл нь бараг бүгдээрээ данслан бүртгэх, дугаарлан тоочих, эмхлэн журамлах, сануулан

захирах өнгө аясаар бичигдсэн байдаг тул тэдгээрт уран зохиолын онцлог төдий л илэрдэггүй. Харин бидний дээр авч үзсэн гэгээд хувилгаадын сүмбүм, түүний дотор багтан уламжлагдаж ирсэн шашин номын мэргэдийн зохиол бүтээл, захиа бичиг, бурхны шашны дэлгэрсэн түүх буюу шашны түүхийн зохиол зэрэг нь уран зохиолын өвөрмөц онцлог, өнгө аясаараа бичиг тэмдэглэлийн бусад эх хөрөнгөд хамаарах сурвалжаас илүү уянгалаг яруу байна.

Гуравт, хэдийгээр намтрын хөрөнгөд хамруулан авч үзэж буй эх хэрэглэгдэхүүн бүхэн нь заримдаа түүхэн үнэний бүрэн дүүрэн баталгаа болж чаддаггүй, нягтлан тодруулах хэрэгцээ шаардлага гарах тохиолдол байдаг ч бичиг тэмдэглэлийн эх хөрөнгө нь аливаа намтрыг туурвих хамгийн үнэ цэн, үүрэг нөлөөтэй эх сурвалж болдгийг тэмдэглэх нь зүйтэй. Зарим тохиолдолд бүр тухайн намтарт гол дүрийн хувиар дүрслэгдэж буй хутагт хувилгаадын өөрийнх нь умартаж мартсан хэрэг явдал, мэдээ баримтыг хүртэл нөхвөрлөх боломжийг бүрдүүлдгийн хувьд чухал ач холбогдолтой хэрэглэгдэхүүн болдог юм. Энэ бүхэн нь бичиг тэмдэглэлийн эх хөрөнгийг түүхэн үнэ цэн, ач холбогдлын хувьд намтар зохиолын хамгийн чухал эх сурвалж хэмээн тодорхойлох гол үндэслэл болж байна.

Abstract:

In this article the author specifically examines the concept of “Biography root” or “Biography root source” that has emerged in connection with autobiography over the course of several hundred years of development, and its part, “Biography root source”. Then, the main sources of “Biography root source” and their general characteristics, content, form, effect, and purpose are summarized. As a result, it is determined that “Biography root source” is the most important source for compiling and writing any biography in terms of historical value and importance, and it is the main reason for considering autobiography as historical literature.

Keywords: Autobiography, root sources, written root sources.

Ном зүй

Лувсанпэрэнлэй. (1995). “*Живзундамба Лувсандамбижалцанбалсанбогийн ердийн товч намтар*”. Гэлэгжамц дооромбын хуучин орчуулгатай тулган нягталж, төвөд хэлнээс орчуулан, эрдэм шинжилгээний удиртгал, тайлбар бичсэн Ш.Бира. “Өндөр гэгээний намтрууд оршивой” - [Öndör gegeenii namtruud orshivoi] Улаанбаатар: ШУА-ийн “Эрдэм” хэвлэлийн компани. [“A brief biography of Jivzundamba Luvsandambijaltsanbalsanbo”. Sh.Bira, who compared the old translation of Gelegjamts Dooromby with the translation from Tibetan, wrote a scientific introduction and commentary. “Biographies of the Undur Gegeen”. Ulaanbaatar: “Erdem” Publishing, Mongolian Academy of Sciences.]

“Сүсгийн зул”. (2010). *“Дээд төрөлхөт Богд Нэйж тойн хутагт вагиндра сумати шасана дуаз сайн цогтын цэдэг долоон эрдэм төгссөн «Сүсгийн зул» хэмээгдэх оршив”*. Алтан-Оргилын эмхэтгэн тайлбарласан “Өвөр Богдын намтар” - [Övör Bogdyn namtar] Хайлаар: Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо. [“Biography of the upper humankind Bogd Nej Toyn Khutaght Vagindra Sumati Shasana Duaz that seven-fold knowledge of “Cresset of belief””. Compiled and Explained by Altan-Orgil “Biography of the Uvur Bogd”. Khailaar: Inner Mongolian Cultural Publishing Committee.]

Агваанлхүндүваржай. (1999). *“Хамгийг айлдагч Агваанчойдогжамц цог сайтын намтар хэтэрхий гайхамшигт сайн зохионгуйн яруу аяст тэнгэрийн ятгын эгшиг хэмээгдэх оршивой”*. Жамьяндампилням орчуулж, Жалсан хянан тайлбарласан “Зургадугаар далай ламын намтар хоёр зүйл” - [Zurgadugaar dalai lamyn namtar khoyor zuil] Хөх хот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.

[“The biography of the great master Agvaanchoidogjamts at named wonderfully organized the sound of the heavenly harp”. Translated by Jamyandampilnyam and edited by Jalsan, “Two Articles on the Biography of the Sixth Dalai Lama.” Khukh khot: Inner Mongolia People's Publishing Committee.]

Лувсансамдүвням. (2010). *“Гэтэлгэгч дээд лам адилтгал үгүй ачит богд Сумадишилаширибадрагийн гэгээний ерөнхийн зохиол намтрыг товчийн төдий өгүүлсэн сүсгийн лянхуаг мөшөөлгөгч нарны гэрэл дээд мөрийг гийгүүлэн үйлдэгч хэмээгдэх оршив”* - [Getelgegch deed lam adiltgal ügüi achit bogd Sumadishilashribadragiin gegeenii yörönhiin zokhiol namtryg товчийн tödii ögүүлсэн süsгийн lyankhuag möshöölögöch narny gerel deed möriig giigүүлэн үилdegch khemeegdekh orshiv] Монгол бичгээс хөрвүүлж, удиртгал тайлбар бичсэн Д.Цэрэнсодном, Д.Наранцэцэг. Улаанбаатар: “Бэмби сан” ХХК.

[“Brief biography of the supreme savior, the supreme lama, virtuous bogd Sumadishilashribadra at named the one who cultivates the lotus of faith, the one who illuminates the path of the sun” . Transcribed from Mongolian traditional script, with introduction and commentary by D.Tserensodnom and D.Narantsetseg. Ulaanbaatar: “Bambi San” LLC.]

Галсанбалжир., Галсан-Иш. (2011). *“«Гурван цагийн бурхадын нийтийн дүрс богд тойн лам Дамцигдоржийн гэгээний намтар хувь сайтны далайд сүсэглэн орох олом» хэмээх оршивой”* - [“Gurvan tsagiin burkhadyn niitiin dürs bogd toin lam Damtsigdorjiin gegeenii namtar khuvi saitny dalaid süse-glen orokh olom” khemeekh orshvoi] Төвөд хэлнээс орчуулж, өмнөх үг бичсэн Ш.Сонинбаяр, Улаанбаатар.

[“The biography of the venerable bogd toin lama Damtsigdorj, the public image of the gods in the past, present, future at named entering the sea of good destiny» Translated from the Tibetan language, with a foreword by Sh.Sonin-

bayar, Ulaanbaatar.]

Агваанбалдан. (2007). “Цорж Агваанбалдангийн намтар” - [Tsorj Agvaanbaldangiin namtar] Төвөд хэлнээс орчуулсан Н.Амгалан. Хянан тохиолдуулсан Ш.Сонинбаяр. Улаанбаатар: “Сэлэнгэ пресс” ХХК.

[“Biography of Tsorj Agvaanbaldan”. Translated from the Tibetan language by N.Amgalan. Edited by Sh.Soninbayar. Ulaanbaatar: “Selenge Press” LLC.]

Дагважанцан. (1995). “Тийн удирдагч Живзундамба их эрдэний намтар магтаалын уг сайн хувьтны сүсэгийг сэргээгч оршивой”. Төвөд хэлнээс орчуулж, өмнөх үг, тайлбар бичсэн Ш.Сонинбаяр. “Өндөр гэгээний намтрууд оршивой” - [Öndör gegeenii namtruud orshivoi] Улаанбаатар: ШУА-ийн “Эрдэм” хэвлэлийн компани. [“The biography of the great leader Jivzundamba at named praise story that restores the spirit of a good destiny.” Translated from the Tibetan language, with a foreword and commentary by Sh.Soninbayar. “Biographies of the Undur Gegeen” Ulaanbaatar: “Erdem” Publishing, Mongolian Academy of Sciences.]

Лувсанцүлтим. (2004). “Хамгийг айлдагч Богд Зонхавын цадиг мэдэхүйеэ хялбараар өгүүлсэн сайн амгалан бүхэн гарахын орон хэмээгдэх оршивой” - [Khamgiig aildagch Bogd Zonkhavyn tsadig medekhüiye khyalbaraar ögüülse sain amgalan бүхэн garakhyn oron khemeegdekh orshivoi] Хуучин монгол бичгийн эхээс сийрүүлэн буулгаж, тайлбар сэлт хийсэн Д.Наранцэцэг. Улаанбаатар.

[“Biography of the great master Bogd Zonkhaba at named a place where all good and peaceful things can come out.” Transcribed from the Mongolian script and annotated by D.Narantsetseg. Ulaanbaatar.]

Агваанлуvsандондов. (2014). “Түгээмлийн эзэн хүрдэн итгэл богд Лувсандамбижанцан цог сайтын цадиг хувь төгөлдөр гэтлэхийг хүсэгчдийн эгээрлийг дүүргэх баяр хурим хэмээгдэх оршивой”. - [Tügeemliin ezen khürden itgel bogd Luvsandambijantsan tsog saityn tsadig khuvi tögöldör getlekhiig khüsegchdiin egeerliig дүүргэх bayar khurim khemeegdekh orshiv] Төвөд хэлнээс орчуулсан Ж.Ерөөлт. Улаанбаатар: “Мөнхийн Үсэг” ХХК.

[“Biography of the great faithful bogd Luvsandambijantsan at named celebration of the enlightenment of those who wish to fulfill their individuality.” Translated from the Tibetan language by J.Yuruult. Ulaanbaatar: “Munkhiin Useg” LLC.]

Лхамаажав Ш. (1995). “Анги Шагдарын намтар зохиол үйлсийн далайн уснаа зорчих сал онгоц хэмээх оршивой”. Төвөд хэлнээс орчуулсан Ш.Сонинбаяр. “Алдарт гүн ухаантан анги Шагдарын намтар тэргүүтнийг нэгэн дор хураангуйлсан дээдсийн сайн номлолын зүрхэн хэмээх судрын чуулган оршивой” - [Aldart gün ukhaantan анги Shagdaryn namtar tergüütниг negen dor khuraanguilsan deedsiin sain nomlodyn зүркхен khemeekh sudryn чуул-

gan orshvoi] Улаанбаатар: “Монгол судар” компанийн “Мөнгөн үсэг” хэвлэх үйлдвэр.

[“The biography of Angi Shagdar at named raft on the sea of the karma”. Translated from Tibetan by Sh.Soninbayar. “The biography of the famous philosopher Angi Shagdar at named a summary of the great sages’ good sermons, which are called the heart of their teachings”. Ulaanbaatar: “Mongol Sudar” company’s “Mungun Useg” printing house.]

Лувсангэлэгданзан. (2014). *Дарба бандидын цадиг «Эрдэнийн эрих»* - [Darba bandidyn tsadig “Erdeniin erikh”] Төвөд хэлнээс орчуулсан П.Ням-Очир. Улаанбаатар: “Амжилтын гарц” ХХК. [“Biography of the Darba bandida «Erdeniin erih»”. Translated from the Tibetan language by P.Nyam-Ochir. Ulaanbaatar: “Amjiltyn garts” LLC.]

Билгийн далай. (2010). *“Богд Нэйж тойн далай манзуширын домгийг тодорхойёо гийгүүлэгч «Чандмань эрих» хэмээгдэх оршив”*. Алтан-Оргилын эмхэтгэн тайлбарласан “Өвөр богдын намтар” - [Övör bogdyn namtar] Хайлаар: Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо. [“The legend of the Bogd Neij Toyn Dalay Manjushir at named “Chandman Erih”. “Biography of the Uvur Bogd”, compiled and explained by Altan-Orgil. Khailaar: Inner Mongolian Cultural Publishing Committee.]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.